



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **СУИС-ийн харъяа ардын зураач Д.Амгалангийн нэрэмжит
Дүрслэх, дизайн урлагийн сургууль**

Сургалтын хөтөлбөрийн нэр: **Уран зураг**

Индекс: **021301**

Шинжээчийн баг:

Ахлагч: ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн багш доктор,
профессор Б.Энхтуяа

Гишүүд: Монголын урчуудын эвлэлийн ерөнхийлөгч профессор Б.Төмөрбаатар
МУБИС-ийн Дүрслэх урлаг технологийн сургуулийн багш, доктор, дэд
профессор М.Моломжамц

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	4
II. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	5
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	9
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	12
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	21
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	28
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	34
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	38
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	43
III. Оролцогчдын нэрс	
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	47
II. Оюутны нэр.....	48
III. Ажил олгогч.....	49
IV. Төгсөгчид.....	50
IV. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	51
Ү. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
ҮI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

II. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

СУИС-ийн хэмжээгээр үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулдаг, тогтмол сайжруулдаг байна.

- Тус хөтөлбөр нь 70 гаруй жилийн түүхтэй Монголын дүрслэх урлагийн ууган мэргэжлүүдийн нэг гэдгээрээ онцлогтой, туршлагатай, нэр хүндтэй хөтөлбөр. Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалдаг. Тайланд нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв байдлыг төрөөс баримтлах бодлогын бичиг баримтад тулгуурлан хийсэн боловч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал хангалтгүй, эхлэлийн байдалтай.
- Төгсөгчийн мэргэжилтний ерөнхий загвар боловсруулсан.
- Уран зураг хөтөлбөрийн шинэчлэн сайжруулах ажил тасралтгүй үргэлжилж, өрнийн болон дорнын урлагийн их сургуулиудад хэрэгжиж буй ижил төстэй сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаанууд хангалттай хийгдсэн ба хийгдсээр байгаа юм байна. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн үр дүн буюу ахиц дэвшил байгаа ч, сул тал буюу доголдолоо илрүүлэх түүнийг хэрхэн сайжруулах тал дээр бага ажилласан байдал ажиглагдсан. Хөтөлбөрийн үр дүнг сургууль бодлогын хувьд нэгтгэн дүгнэх, түүнийгээ сайжруулах боломж байна.

Анхаарах асуудал:

- Уран зураг сургалтын хөтөлбөрийн мэргэжлийн хичээлийн цаг, мэргэжлийн дадлагажих цаг гадны ижил төстэй сургуулийн хөтөлбөртэй харьцуулахад маш бага байна. 28 дугаар хуудаснаас харахад онолын хичээлийн цаг нь нийт цуглуулбал зохих 130 кр цагийн 1/3 хувиас давсан байгаа нь харагдаж байна. Өндөр хөгжилтэй ижил төстэй мэргэжлийн сургуулиудад өдөр бүр мэргэжлийн хичээл орж байдаг ба үүний үр дүнд чадварлаг зураач төрнө гэдгийг орхигдуулсан байна.

Зөвлөмж:

- Сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээнд тогтмол дүн шинжилгээ хийдэг болох, шинжилгээний үр дүнг (тэдний эрэлт хэрэгцээг хангахад) сургалтын хөтөлбөрт хэрхэн тусгах талаар бодлого, төлөвлөлт хийж ажиллах.
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загварыг хөтөлбөр дахь 3 мэргэжил тус бүрээр гаргах, боловсруулах.
- Ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийхдээ ялгаатай, давуу, сул тал, онцлог, сайжруулах боломжоо харж тодорхойлох, хэлбэр бус (хичээлийн нэр, кредит) агуулгын хувьд ч мөн харьцуулалт хийх
- Доктор хамгаалсан сэдвээр нь багшлуулвал зүйтэй гэж үзэж байна
- Уран бүтээлч талаа илүү барьж сургалт явуулах сэтгэлгээг голлож явуулах. Үүний тулд дэлхий нийтээр олон зууны туршид уламжлагдаж ирсэн урлангийн системээр сургалтыг явуулах.
- Багшлах бүрэлдэхүүнд туршлагагүй багш нар олон байгаа нь ажиглагдлаа, иймд туршлагатай ахмад багш нарыг урьж залуу багш нараа дагалдуулан заах аргад суралцуулан чадваржуулах.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол зураг, уран зургийг хослуулсан онцлогтой, уран зургийн үзэл баримтлал хөтөлбөрт давамгайлсан. Сургалтын хөтөлбөр нь 1945 оноос хойш тухайн мэргэжлийн хичээлийг заах багш нарын сургалтын арга зүй, туршлагаар баяжсан. Хөтөлбөрт тусгасан мэдлэг, чадварыг ямар арга замаар оюутанд олгох нь нэр хүнд бүхий гадаадын их дээд сургууль төгссөн, өндөр боловсролтой, авъяастай, олон жилийн туршлагатай тухайн багшийн сургалтын заах арга зүйгээр олгогдож чөлөөт байдлаар зохицуулагдаж ирсэн туршлагатай. Багш нар болон оюутны шилдэг бүтээл шалгаруулах уралдаан үзэсгэлэн жил бүр зохион байгуулж байгаа нь тэдний ур чадвар хэрхэн өсч хөгжиж байгааг зах зээл, хэрэглэгчдэд таниулах сайн талтай.
- Их дээд сургуулиудад ашиглагддаг үнэлгээний тогтсон системийг ашигладаг. (70:30, UNICULTURE)
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилттой бичиг баримтын боловсруулалтын хувьд нийцсэн.

Анхаарах асуудал:

- Оюутан суралцаж буй хугацаандаа нэг биш олон багшийг сонгон суралцах боломжийг нээж өгсөн дэвшилтэд арга хэрэглэдэг болсон нь ажиглагдаж байгаа боловч уг хөтөлбөр мэргэжлийн онцлог, урлангийн системийн давуу талууд алдагдсанаар сургуулийн онцлог болох уламжлалт арга зүй-урлангийн системээр мэдлэг чадварыг оюутанд олгох чөлөөт байдлын хэв шинжээ алдахад хүрч болзошгүйг анхаарах шаардлагатай болжээ.
- Хэдийгээр гадаадад төгссөн шинэ залуу багш нарын тоо нэмэгдэх хандлага байгаа нь сайн талтай ч энэ мэргэжил нь авъяас, ур чадвар, туршлага дээр их тулгуурладаг тул төгсөгчдөд мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, тэдний хандлагыг зөв чиглүүлэхэд тавигдах шаардлагыг хангахад учир дутагдалтай.
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч бүх талуудын төлөөллийн саналыг тусгах, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт тэдгээрийн төлөөллийг оролцуулдаг байдал нотлогдохгүй байна. Энэ нь зөвхөн төгсөгч багшаар хязгаарлагдаж байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан 2014 оноос “ДДУС-ийн Оюутны шилдэг бүтээл” шалгаруулах уралдааныг жил бүр уламжлал болгон тасралтгүй үргэжлүүлэн зохион байгуулахыг зөвлөж байна.
- Сургуулийн эрхэм зорилго, зорилт болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн нийцтэй байдлыг авч үзэхдээ хөтөлбөрийн онцлогийг илүү харгалзах шаардлагатай.

- Хөтөлбөрийн үнэлгээний систем нь мэргэжлийн онцлогт тохирсон өөр байх боломжтойг анхаарч үзэх.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой харьцааг хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан, баталгаажуулалт хийгдсэн.
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг дээд боловсролын шаардлагад нийцүүлэн тодорхой хэмжээнд хослуулсан, мэргэжлийн онцлогт тулгуурлан суралцагчдад олгох мэдлэг, ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байна.
- Хичээл тус бүрийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг аль болох тусгах тал дээр тодорхой хэмжээнд анхаарч ажилласан байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөлтөөр онол, практикийг зохистой хослуулах, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чадварлаг туршлагатай зураачид, орчин үеийн график зураглалын программистуудыг, дизайнеруудыг багшлуулах нь зүйтэй.
- Хөтөлбөрийн төлөвлөлтийн бичиг баримт нь их дээд сургуулиудын нийтлэг стандарт бичиг баримтад хэт баригдмал, хөтөлбөрийн өөрийн онцлогийг бага харгалзсан.

Зөвлөмж:

- Сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулах.

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн бичиг баримтыг стандарт загварт баригдалгүй Уран зураг хөтөлбөрийн онцлог, олон улсын мэргэжлийн жишгийг харгалзан өөрчлөх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн зорилго зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлэхээр сургалтын бус зориулалтаар баригдсан байгууламжуудыг сургалтын стандартад нийцүүлэн өөрчлөн шинэчлэх ажлыг эхлүүлэн идэвх чармайлттай ажиллаж байгаа нь харагдаж байна.
- Төсөв, санхүүгийн хязгаарт нөхцөл байдалдаа тохируулан сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслийг нийтлэг стандарт байдлаар, лаборатори-урлангийн ашиглалт дотоод нөөц, мэргэжлийн багш нарын санаачилга, хичээл зүтгэлээр засаж тохижуулах байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт төдийлөн сайн биш.

Анхаарах асуудал:

- Хичээлийн байр нь 3 тусдаа хичээллэж байгаа нь сургалтад сөргөөр нөлөөлж, хичээлүүдийн байрны хооронд цаг алдах, сургалтын нэгдсэн бодлого явуулахад хүндрэлтэй байгаа нь харагдаж байна.

- Сургалтын стандартад нийцсэн орчин бүрдүүлэхэд СУИС-ийн удирдлагаас шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэхэд удирдлагын санаачлага сул байна.

Зөвлөмж:

- Сургалтын төвлөрсөн нэг байртай болгох шаардлага, хэрэгцээ байгааг анхааран цаашид хөтөлбөрийн нэг зорилтоо болгох
- Баш, оюутны сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлангийн ажиллах орчин, багаж хэрэгсэлийг мэргэжлийн стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг бодлого болгон тасралтгүй үргэлжлүүлэх.

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгсэл

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн мэргэжлээр ашиглах орчин үеийн программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хангамж хүртээмж хангалттай эсэх нь баримтаар нотлогдоогүй.
- Хичээл практикийн материаллаг нөөцийг сургууль тодорхой хэмжээгээр, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүнийг багш нар хичээл бүрээр бэлтгэн сургалтанд ашигладаг. Сургуулийн мэргэжлийн онцлогоос шалтгаалан натюрмортын үндсэн фондыг байнга баяжуулах шаардлага гардаг байна. Үүнийгээ баяжуулахын тулд шинээр элссэн оюутнуудын хэрэглээнээс гарсан эд эдэлхүүнээр фондоо баяжуулдаг нь эдийн засгийн болоод экологийн хувьд ач холбогдолтой сайн туршлага байна.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж сайн.

Анхаарах асуудал:

- Орчин үеийн нийгмийн шаардлага хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцийн хангалтыг сайжруулах шаардлагатай.
- Программ хангамж, симуляци, виртуал лаборатори байхгүй
- Хичээл практикийн хэрэглэгдэхүүнийг оюутнууд өөрсдөө гол төлөв гаргадаг

Зөвлөмж:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторитой болох
- Хичээлийн хэрэгслийн хүрэлцээ хангамжийг оюутны хичээл практикийн зардалд тусган, төсөвт оруулж нэмэгдүүлэх

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ боломжийн хэмжээнд байна.
- Залуу багш нар өөрийн заадаг тодорхой хичээлийн хүрээнд виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим “нээлттэй” эх үүсвэрүүдийг тодорхой хэмжээнд ашигладаг.
- Цахим орчноос багш, оюутнууд тодорхой хэмжээнд мэдээлэл авч ашигладаг. Багш нарын үзэсгэлэнд гаргасан бүтээлээр ном товхимол хэвлэн гаргадаг болсон.
- Дээд боловсролын суурь хичээл болон багш, оюутны компьютерийн хэрэглээнд лицензтэй программыг ашигладаг.

Анхаарах асуудал:

- Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байдал төдийлөн сайн биш.
- Виртуал, дижитал видео, аудио эх үүсвэр хангалтгүй, бусад цахим эх үүсвэрийн хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Сургалт, судалгааны лицензтэй программгүй.

Зөвлөмж:

- Дэлхийн нэр хүнд бүхий орчин үеийн урлагийн сэтгүүлийг байнга номын санд захиалж байх, нэмэгдүүлэх замаар оюутан суралцагчдыг шинэ мэдээллээр хангах.
- Сургалт, судалгааны лицензтэй программтай болох

- Дэлхийн улс орнуудад зохион байгуулагдаж буй урлагийн арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг цаг тухай бүрт нь цахим орчны мэдээллээс авах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн баазтай болох.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн профессор багш нар хөтөлбөрийн зорилгыг СУИС, ДДУС болон тэнхимийн эрхэм зорилго, зорилтуудтай уялдуулан, төгсөгчдөд тавьсан шаардлагыг хангахын тулд тодорхой ажлуудыг төлөвлөн ажиллаж, сургалтын орчин, техник тоног төхөөрөмжийг бий болгоход СУИС, ДДУС-ийн удирдлагын дэмжлэгийг авч ажилласан байна. Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдлыг хангах болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад оролцогч талуудын оролцоог хангах, хөтөлбөртөө дүн шинжилгээ хийх, аливаа санал, гомдолыг хүлээн авах, хариу өгөх, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгах, ажлын гүйцэтгэл, үр дүнг

урамшуулах механизм/систем бүрдүүлэх талд тодорхой санал санаачилга, ахиц дэвшил гаргахад үйл ажиллагаагаа чиглүүлж ирсэн байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын чанарт гарах эерэг өөрчлөлт байнга хийх, сайжруулах
- Нийгэм эдийн засгийн байдлаас хамааран хөтөлбөрөөр суралцагчдын тоо нь хэлбэлзэлтэй байдаг.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм журмын хэрэгжилтийг тайланд бүрэн тусгах, удирдлагаас байнга урамшуулан дэмжих
- Хөтөлбөрөөр суралцагчдын тоог тогтмол хэмжээнд барих бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгаа нь их сургуулийн хэмжээнд төслийн санхүүжилтээр хийгдсэн боловч их сургууль хөтөлбөрийн хувьд байнгын болж хэвшээгүй байна.
- Мэргэжлийн онцлогоос хамааран хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт нь ихэвчлэн үзэсгэлэн, хэвлэмэл бүтээгдэхүүн, фэйсбүүк, сургуулийн сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин явагддаг онцлогтой байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж хангалтгүй.
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Нийгмийн хэрэгцээ, захиалгаас хамааран хөтөлбөрийн сурталчилгааг хэвлэл мэдээлэл, хэвлэмэл бүтээл болон үзэсгэлэнгээр олон нийтэд сурталчилахаас гадна сурталчилгааны бусад хувилбарыг ашиглах.
- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох, түүний дагуу ажиллах.

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Үе үеийн уран бүтээлчдээс суралцагч оюутнууд үзэсгэлэн, уулзалт ярилцлага, хэлэлцүүлэгт хамтран орж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хөтөлбөрийн сургалтанд гарч буй давуу ба сул талуудыг байнга хэлэлцэж байдаг нь хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, мэргэжлийн чиглэлээр ажиллахад зөвлөн тусладаг байдлыг илтгэж байна.

- Тус хөтөлбөрөөр суралцаж төгссөн уран бүтээлчид Венецийн биенналь, Норд-Арт, Бээжин биенналь, Берлин зэрэг дэлхийн хэмжээний уралдаанд удаа дараалан амжилт үзүүлсэн нь төгсөгчдийн карьерын өсөлтөнд өндөр ач холбогдол өгдөг байна. Төгсөгчид нь Монголын болон гадаадын олон их дээд сургуулиудад мэргэжлээрээ багшилж байгаа тэднээс доктор, профессор, гавъяатууд олноор төрж гарсан нь энэ хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн болон хувь хүний ур чадвараар тодорхойлогдоно. Төгсөгчид бие даасан уран бүтээлч болох, карьерын өсөлтөд Монголын Урчуудын эвлэлийн хорооны гүйцэтгэсэн үүрэг их байна.
- Төгсөгчид нь гадаад болон дотоодын магистр, докторын сургалтанд үргэлжлүүлэн суралцах боломж өндөр байгаа нь 2010 оноос 2017 он хүртэл магистрантур, докторантурт суралцагчдын тоон өсөлтөөс харагдаж байна.
- ОХУ-ын Москва хотын В.И.Суриковын нэрэмжит академи, Санкт-Петербург хотын И.Е.Репиний нэрэмжит уран зургийн академуудтай хамтран багш нар болон төгсөгч, төгсөх ангийн оюутнуудаа мастер класс сургалт зохион байгуулж давтан сургалтанд хамруулах ажлыг бодлого болгон, төлөвлөж хэрэгжүүлж хэвшсэн байна. Монголын цагдаагийн академтай хамтран зураач шинжээчээр тодорхой төгсөгчдийг бэлтгэсэн байна.
- Төгсөгчдийн холбооны олон нэр бүхий нэгдэл, бүлгэм ажиллаж байгаа бөгөөд гол нэгдсэн байгууллага нь Монголын Урчуудын Эвлэлийн хороо. Зураач уран бүтээлчдийн “Дүрслэх урлаг” сэтгүүл сэргэж гарснаар захиалагч уншигчдын өргөн хүрээг хамрах болсон. Соёлын хүрээлэнгээс гаргасан “Соёл урлагийн тайлбар толь” цуврал боть гарсан нь уран бүтээлчдийн намтар түүх, урлагийн танин мэдэхүйн ач холбогдолтой хөтөлбөрт ашиглах томоохон бүтээл болсон. Уран бүтээлийн үзэсгэлэнгүүдийг тодорхой давтамжтай гаргаж уран бүтээлч, суралцагч оюутнууд байнга хамруулдаг нь тэд бие биенээсээ харилцан суралцах томоохон уламжлалт ажил болж хэвшсэн байдаг.

Үүний үр дүнд төгсөгчдийн карьерийн өсөлтийн судалгаа нь аль ч цаг үед байнгын өсөлттэй байна.

Анхаарах асуудал:

- Цаашид уламжлалт байдлаа үргэжлүүлэн хадгалах: Дүрслэх урлагийн дунд сургууль байхад суралцаж байсан хөтөлбөрүүдийн зарим хэлбэрүүд одоог хүртэл үнэ цэнээ алдаагүй тул түүнийг хөтөлбөрийн өнөөгийн байдалд нийцүүлэн сургалтанд оруулах нь сургалтын чанар дээшлэх, оюутнуудын ур чадвар нэмэгдэх, төгсөгчдийн карьерын өсөлтөд давуу тал болох боломжтой.
- Хөтөлбөр дэх дээд боловсролын болон мэргэжлийн суурь гол хичээлүүд, мэргэжлийн хичээлүүдийн тоо буурсан, дээд боловсролын суурь хичээлийн агуулга мэргэжлийн онцлогоос ангид нийтлэг зарчмаар орж байгаа нь төгсөгчдийн ур чадварт сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Зөвлөмж:

- Төгсөлтийн дараах бодлого, төлөвлөлтийг тасралтгүй сайжруулах
- Төгсөгчдийн карьерын өсөлт, үргэлжлүүлэн суралцах, давтан сургалтанд хамрагдсан байдлын судалгааг хийж хэвших
- Төгсөлтийн дараах бодлого, хөтөлбөр нь мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, судалгаанд чиглэх. Төгсөгч энэ мэргэжлээр сурч төгсөөд зах зээлд хөрвөх чадвартай уран бүтээлч болох талаас хөтөлбөрийн агуулгад тусгаж өгвөл сайн байна.
- Мэргэжлийн хамтын ажиллагааг урамшуулах, алдаршуулах.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Сургуулийн хамтарсан төсөлд гадаадын болон дотоодын үйл ажиллагааг хангасан хэсгүүд байсан бөгөөд их дээд сургуулийн сургалт, судалгааны байгууллагын үзүүлэлтэнд нийцсэн байна.

Олон улсын их сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, судалгаа, семинар зохион байгуулах ажил тогтмол хийгддэг байна. Мөн багш оюутны солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагддаг байдал боломжийн хэмжээнд байна.

- Хөтөлбөрийн нэг хэсэг болох сургалтын орчин хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх сайжруулах, хангах зорилгоор БНХАУ-тай хамтран ажиллах хүрээнд натюрмортын фондоо баяжуулсан байна. Тонляогийн Үндэсний их сургуульд ӨМӨЗО-ны урлагийн дээд сургуультай хамтран гаргасан уран бүтээлийн хамтарсан үзэсгэлэн нь гадаад харилцаагаар дамжуулан мэргэжлийн ур чадварыг сурталчилсан нэг томоохон ажил болжээ.
- ОХУ-ын Барнаулын их сургуультай хамтарсан “Монгол Алтай” төсөлд судалгааны баг ажилласан, Монгол, ОХУ, ХБНГУ-тай хамтарсан Хэнтий, Баян-Өлгий аймгийн нутагт байдаг хадны зургийн судалгааг гурван жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн нь эрдэм шинжилгээний судалгааны томоохон бүтээлийн нэг болсон байна.
- ОХУ-ын Эрхүү хотын Урлагийн сургууль, БНСУ-ын Тэжон хотын “ОК” корпораци, Эрхүү хотын ДИАС уран зургийн галлерейтай хамтарсан судалбар зургийн баг уран бүтээлчид солилцсон нь гадаад хамтын ажиллагааны томоохон хэлбэр юм.
- Багш нараас ХБНГУ-ын Дортмундын их сургуульд зохиогдсон эрдэм шинжилгээний хурал, АНУ, Парис, БНХАУ, БНСУ, Канад зэрэг олон оронд хурал семинар, үзэсгэлэн, биеннальд амжилттай оролцсон нь хөтөлбөрт нөлөөлөх гадаад хүчин зүйл бөгөөд туршлага харилцан суралцах боломжууд болсон байна. Мөн багш нарыг Сингапур, Малайз, БНХАУ-ын Хөх хот, ОХУ-ын Красноярск хот, Австри зэрэг олон оронд хурал семинарт оролцуулсан нь мэргэжлийн төрөл чиглэлээр багш, судлаачдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд үр дүнтэй, ач холбогдолтой юм. БНСУ-ын Чоннам их сургуульд багш зураач Б.Нямхүү нь бие даасан үзэсгэлэнгээ гаргасан нь хоёр орны урлагийн хамтын ажиллагаа болон солилцоонд давуу тал болсон зэрэг олон ажлууд нотлох баримтаар баталгаажсан.

Анхаарах асуудал:

- Багш оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах байдал хэдийгээр хийгдэж байгаа боловч богино, дунд, урт хугацаанд түүнийг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх, энэ үйл явц хөтөлбөрт хэрхэн нөлөө үзүүлэх, түүнийг хэрхэн хэмжих тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.
- Элсэн суралцах оюутны тоо буурах хандлага нь тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах оюутны тоо цөөн байхад нөлөөлөх магадлалтай. Тиймээс гадаад оюутны элсэлтийг нэмэгдүүлж эргээд өөрийн оюутнуудыг хамтарсан хөтөлбөрт хамруулах боломжуудыг судлах. Хамтарсан хөтөлбөрийн 2+2, 3+1, гэх зэрэг боломжуудыг судлах.
- Ахисан түвшинд суралцах боломж, тэтгэлэг гол төлөв суралцагчдын хувийн санаачлага дээр суурилж байна.

Зөвлөмж:

- Судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх
- Дүрслэх урлагийн суурь судалгааны чиглэл давамгайлсан судалгааны ажилд мэргэжлийн ур чадварыг илүү ашигласан, чиглүүлсэн хандлагатай байх боломжтой.

- Залуу багш нарыг докторантур болон докторын дараах сургалтанд хамруулах, судалгаа хийх нөхцөл, төсөлд оролцох цаг боломж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дотоодын нөөц бололцоог хангалттай сайн ашиглан мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг, хөтөлбөрийн хэрэгжилт болон боловсруулалтандаа тэдний зөвөлгөөг тусгаж ажиллаж байна. Тухайлбал, Монголын урчуудын эвлэлийн хороотой хамтран ажиллаж байгаа багш, суралцагч, төгсөгчид нь гишүүнчлэлд орох, уран бүтээл туурьвах, суралцах хугацаандаа харилцан суралцах боломжуудаар бүрэн хангагдаж байдаг.
- Сургуулийн хэмжээнд нийт багш нараас мэргэжлийн ур чадвараар өөрийн болон олон улсад танигдсан уран бүтээлчид олон байна. Их сургуулийн дотоод хамтын ажиллагаа болон хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага, холбоодын олон талт хамтын ажиллагааны хүрээнд Төрийн шагналт, ардын зураач Д.Амгалан, Төрийн хошой шагналт, ардын зураач О.Цэвэгжав, Урлагийн гавъяат зүтгэлтэн С.Дондог, Төрийн шагналт зураач Б.Пүрэвсүх нарын ар гэр, үр хүүхдүүдтэй хамтарч мэргэжлийн урлангийн тохижилтыг сайжруулсан байна.
- Монгол зургийн мэргэжлийн сургалтын материалыг сайжруулах зорилгоор магистр багш М.Чинбат, С.Ганзам, ахлах багш Н.Сэргэлэн нарын “Хосгүй үнэт” бүтээлийг хуулбарлан хийх төсөл нь дотоод хамтын ажиллагааны давуу талууд болсон байна.
- Цаашид энэ мэт төсөл, бүтээлч арга ажиллагааг сургалттай хослуулан хийх нь мэргэжлийн давуу талууд болно.

- Элсэлтийн бодлогын нэг хэсэг болох Баянхонгор аймгийн Тэмүүжин театрт хамтран хүүхдийн гар зургийн уралдаан зохион явуулж, мэргэжил хөтөлбөр сурталчилж, 6 хүүхдэд СУИС-д суралцах эрх олгосон байна.
- Хөдөө орон нутгийн хүүхдүүдэд хүрч мэргэжлийн урлагийн сурталчилгааг сайн явуулснаар хөтөлбөрөө сурталчлах бас нэгэн үзүүлэлт болж байна.
- “Гэмт этгээдийн ам зураг зурах” онол арга зүйн сургалтыг Цагдаагийн байгууллагын 200-н албан хаагчдыг хамруулсан зэрэг олон ажлын үр дүн байна.
- Хөдөө орон нутгийн урчуудын салбаруудтай хамтарч элсэлтэд өргөн хүрээтэй хамруулах бодлогоор олон арван ажлуудыг зохион явуулсан байна.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний тоо, хамруулсан хүрээний хувьд сургууль, тэнхимийн зүгээс олон арга хэмжээ зохион байгуулдаг болсон нь дээрх тайланд тусгагдсан ажил болон нотлох баримтаар баталгаажиг байна.

Анхаарах асуудал:

- Цаашид их сургууль доторх болон мэргэжлийн, мэргэжлийн бус байгууллагатай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн, харилцаагаа хадгалан өргөжүүлж ажиллах
- Мэргэжил сурталчилсан томоохон ажлуудаа телевиз радиогоор сурталчлах, нийтэд мэдэгдэх, олны хүртээл болгох тал дутагдалтай байна.
- Багш, оюутны бүтээл түүний санаа нь нийгмийн захилгат, олон улсад хэмжээнд үнэлэгдэхүйц гэх мэт тохиолдолд будаг, материал хэрэгслээр бүрэн хангах асуудлаар бусад байгууллага хувь хүн компаниудаар ивээн тэтгүүлэх, дэмжлэг хүсэх тал дээр удирдлагаас санаачлагатай ажилладаг байх.

Зөвлөмж:

- Хамтын ажиллагааны арга туршлага дээрээ тулгуурлан нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн үр дүнг сайжруулах, хөгжүүлэхэд алдар цолтой, нэрт уран бүтээлчдийн уулзалт, ярилцлага тогтмол зохион байгуулах түүгээр дамжуулан тэдний зөвөлгөөг сургалтын үр дүнтэй уялдуулан тодорхой хугацааны дараа үр нөлөөг үнэлж, дүгнэж хэвших боломжтой.
- Монголын урчуудын эвлэлийн хороо болон бусад оролцогч талуудтай хамтран сургалт, судалгааг хийх, хөтөлбөрийн дунд, урт хугацааны стратегиа тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах боломжтой.
- Монголын урлагийн салбарт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж байсан 1960-1990 оны үед Дүрслэх урлагийн дунд сургууль, Циркийн дунд сургууль, Хөгжим бүжгийн дунд сургуулиуд Монгол улсын соёлын яамны харьяа байсан буюу мэргэжлийн байгууллагын шууд удирдлагад байсан юм. Одоо БСШУЯ-д хамаарч байгаа ба Монголын урлагийн хойч үе болон ирээдүйг бэлтгэж байгаа нарийн мэргэжлийн сургуулиудыг илүү анхаарч үзэх нь зүйтэй.

- Томоохон уралдаанаар бүтээлээ урлаг сонирхогч ард түмэнд таниулах сурталчлах боломжийг бүрэн ашиглах нь хөтөлбөр мэргэжлийн онцлог, үр дүнг нэмэгдүүлэх боломжтой.
- Зургийн мэргэжлийн сургалтын онцлог, давуу талыг сурталчлахад нэртэй уран бүтээлчид болон мэргэжлийн эрдэмтэн мэргэдүүдийг татан оролцуулах, тусгай нэвтрүүлэг хийж хэвших нь хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулахад тустай.
- Монгол улсын хэмжээнд бүх аймаг орон нутгийн удирдлагуудтай хамтран хөтөлбөр мэргэжилээ сургалчилах ажлын хүрээнд үйл ажиллагаануудыг өргөн зохион байгуулах, уран зургийн гоо зүйн боловсрол мэдлэг орон нутагт түгээх, хүүхдийн авьяасыг илрүүлэх, гаргасан бүтээлд тулгуурлан элсэлт авах боломжтой.

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг боловч олон эх үүсвэргүй. Үндсэн үйл ажиллагааны орлогын өсөлт нь жил бүрийн оюутны тоо болон сургалтын төлбөрийн өсөлттэй холбоотой бөгөөд үүнээс үл хамааран багш оюутны хөгжлийн чиглэлээр сургалт семинар, үзэсгэлэнгүүдэд санхүүгийн дэмжлэг туслалцааг үзүүлсээр иржээ.

- Урлагийн салбарыг хөгжүүлэх нэг томоохон хөшүүрэг бол санхүүжилт бөгөөд тухайн салбарын хэрэгцээнд өөрт нь захиран зарцуулах эрхийг өгөх явдал юм. СУИС -ийн төв удирдлага нь салбар сургуулиудад санхүүгийн захиран зарцуулах эрхийг бага өгдөг нь баримтаар харагдаж байсан. Жишээ нь, магистр, доктор элссэн тохиолдолд тэдгээрийн сургалтын төлбөрийг салбарт 70 хувь орж байж хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжоор хангагдах тогтолцоотой. ДДУС Монгол улсын төсвийн тухай хуулийн шилэн дансны хуулийн дагуу төсөв захиран зарцуулалтын тайлагналыг хийж байна.
- Нэг сурагчид ноогдох зардал нь 2011-2012 онд 942,586,88 төгрөг байсан бол 2016-2017 оны байдлаар 2,181,308,94 төгрөг буюу 2,3 дахин өссөн дүнтэй байна.

Элсэгчдийн тоо цөөрсөн нь орлого буурахтай шууд хамааралтай байна. Мэргэжлийн сургуулийн элсэгчдийн тоо нь нэг багшид ноогдох харьцаа алдагдахад нөлөөлсөн. Элсэгчдийн тоо нэмэгдэх тусам нэг багшид ноогдох суралцагчдын хэрэглээний зардал буурах магадлалтай байна.

Мэргэжлийн уран бүтээлч бэлтгэж байгаа тухайн сургуулийн хувьд урлангийн зарчимаар сургалт явагддаг нь санхүүгийн зардал өндөр гарах нэг нөхцөл болж байна.

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэл, өөрчлөлтөд чиглэсэн санхүүгийн дэмжлэг бага байгаа нь харагдаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт багш, оюутанд хандсан өөрчлөлтүүдэд зарцуулсан зардлыг харуулсан баримт бага байгаа нь сургалтанд тэр тусмаа хөтөлбөрт хандсан мөнгөн дэмжлэг байхгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна.
- Урлагийн нарийн мэргэжлийн чадварлаг боловсон хүчин бэлтгэж байгаа мэргэжлийн сургуулийн санхүүжилтэнд төрийн болон хувийн хэвшлийн дэмжлэг муу байна. Уран зургийн мэргэжил нь суралцах хугацаандаа зургийн хэрэглэгдэхүүн маш ихээр зарцуулдаг бөгөөд түүний өртөг өндөр байдаг. Урлагийн мэргэжлүүдийн дотроос уг хөтөлбөр дэх мэргэжилүүд нь хувь оюутандаа өртөг өндөр, зардал их гардаг тул, төр болон салбарын яамны онцгой анхаарах шаардлагатай мэргэжил гэж үзэж болно.
- Боловсролын зээлийн сангаас олгож байгаа зээлийн хүү өндөр байгаа нь тухайн суралцагчид хүндрэлтэй байгааг нотлох баримт 2016 оны санхүүгийн тайлан дахь нийт орлого 999,844.3 төгрөгөөр харж болно.
- Төсвийн санхүүжилтийн өсөлт бууралт харуулсан нотлох баримтаас нийт зардал 2016 оны байдлаар 354,310.01 төгрөг байгаа бол хөтөлбөрийн цэвэр орлого 15,632.39 төгрөг байгаа нь харьцангуй бага юм.
- Бусад эх үүсвэрийн баримтаар “Хосгүй үнэт бүтээл” төслийг хэрэгжүүлэх замаар дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа Гэндэндамбын “Улаан сахиус” танка зураг, Агвааншаравын “Өндөр гэгээний хөрөг” танка зургуудыг хуулбарлан бүтээж 28,958.0 мянган төгрөгний орлого оруулсан байна. Энэ мэт бусад эх үүсвэрийн орлого бага байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд санхүүжилт хангалтгүй байгааг илэрхийлнэ.
- Төгссөн оюутнуудын дипломын ажлыг борлуулсан орлого төсвийн орлогод орсон, тодорхой хувь эзлэх боломжтой боловч хэдэн төгрөг орсныг харуулсан нотлох баримт үгүй байна.

Анхаарах асуудал:

- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо хөтөлбөрийн онцлогтой бус СУИС-ын 1 оюутанд ноогдохоор тодорхойлогдсон.
- Нэг оюутанд ноогдох зардлын хэмжээг тодорхойлохдоо их сургуулийн хэмжээнд тухайн хөтөлбөр мэргэжлийн онцлогийг харгалзан тодорхойлох шаардлагатай.

- Мэргэжлийн онцлог нь бүтээл хийх чанарын шаардлага хангасан будаг, цаас, сургалтын хэрэглэгдэхүүнүүд үнэтэй байдгаас нэг оюутанд ноогдох санхүүгийн хүндрэлүүд их байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв харьцангуй бага.
- Төр болон салбар яам, хувийн хэвшлийн дэмжлэгээр хийгдсэн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.
- Санхүүгийн дэмжлэг энэ мэргэжил дээр муу байгаа нь суралцагч, элсэгчдийн тоо, цаашдаа монголын дүрслэх урлагийн ирээдүйд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

Зөвлөмж:

- Уг хөтөлбөр, мэргэжлийн онцлог нь бага бүлгээр хичээллэх зайлшгүй шаардлагатай байдаг учраас урлангийн системийн онцлог, сургалтын ач холбогдлын талаарх асуудлыг БСШУЯ-ны сургалт явуулах дүрэм журам, их сургуулийн эрх зүйн акт, шийдвэрт бодлогоор тусгуулах, зохицуулалт хийх боломжтой.
- Боловсролын яам нарийн мэргэжлийн энэ мэт сургалтуудад бодлогын болон санхүүгийн дэмжлэг туслалцааг хангаж өгөхгүй бол тухайн мэргэжил чадварлаг боловсон хүчнээр хангагдаж чадахгүйд хүрнэ.
- СУИС-ийн удирдлагын зүгээс энэ мэргэжлийн сургалт хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дээд байгууллага болон боловсролын яаманд тусгайлан хандах шаардлагатай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс төр хувийн хэвшлээс санхүүгийн дэмжлэг авах, төсвийн уламжлалт бус бусад эх үүсвэрийг олоход илүү санаачилгатай ажиллах боломж байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа

- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дүрслэх урлагийн болон уран зургийн мэргэжлийг сонгон суралцах элсэгчид цөөрсөн хандлага ажиглагдаж байна. Энэ нь суралцах хугацааны материалын өртөг өндөр, мэргэжлийн хичээлүүдийн ачаалал болон суурь хичээлүүдийн хөтөлбөрийн харьцааг зөв тэнцвэржүүлэх асуудалтай холбоотой гэж үзэж байна.

- Уран зураг мэргэжлийн элсэгчид өөрийн ур чадварт гурван төрлийн шалгуур үзүүлэлтээр шалгагддаг бөгөөд 800 оноо дээд үзүүлэлт болно. Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог 400 гэж тогтоосон элсэлтээ авч байна. Элсэлтийн бодлого дахь хөтөлбөрийн шалгуур нийцэж байна гэж үзэж байна.

- Элсэх хүсэлт гаргасан болон элссэн суралцаж буй оюутны харьцаа зөрүүтэй байгаа нь сургалтын төлбөр төлөх чадамжгүй, мэргэжлээ буруу сонгосон гэх мэт бусад сургуулиудад байдаг нийтлэг шалтгаантай адил байна.

- Шинээр элссэн оюутнуудын сургалтад бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд шаардлагатай боломжоор хангах тал дээр өндөр ур чадвартай, олон жилийн суурь туршлагатай багш нар ажиллаж байна. Нотлох баримтаар мэргэжлийн ур чадварт болон урлагийн хүн болох суурь чадамжинд хангалттай тусалдаг байна.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн бодлогод зөв менежмент хийж сургууль мэргэжил сурталчилах боломжуудаар хангах.
- Уран зургийн хөтөлбөр элсэлтийн маркетинг төлөвлөгөөг боловсруулж ажиллах.

Зөвлөмж:

- Оюутны элсэлтийн бодлогод өөр нэмэлт бодлого баримтлах хэрэгтэй. Их дээд сургуулиудын консерциумд СУИС-аас гадна Дүрслэх урлагийн сургуулийн бие төлөөлөгч ажиллуулах, мэргэжил сурталчилсан нэвтрүүлэг, сургалт үзүүлэн таниулах олон талт ажиллагааг хот хөдөөгийн хэмжээнд өргөн зохион байгуулах нь зөв юм.
- Ижил төстэй хөтөлбөр, мэргэжлээр мэргэжилтэн бэлдэж байгаа хувийн хэвшлийн их дээд сургууль болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг өрсөлдөх чадвартай гэж үзэн улсын томоохон их сургууль, хөтөлбөрийн хувьд давуу тал түшиглэн элсэлтийн маркетингийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ажиллах боломжтой

- Мэргэжлээ сурталчилсан бодлого үйл ажиллагааг тасралтгүй явуулах нь элсэлтийн бодлогын гол давуу тал болно.

4.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Урлагийн чиглэлд суралцдаг оюутнуудын бие хүний төлөвшил, урлагаар дамжуулж нийгэмд хандах хандлага харилцааг мэдрэх нь хөтөлбөрийн хувьд өөр байдаг. Уулзалт хийсэн оюутнуудын ярьж байгаа, мэргэжлээ үнэлж дүгнэж байгаа нь мэргэжлийн хувьд бие хүний хандлагыг тодорхойлж байсан. Тэд уран бүтээл хийхийн тулд уг мэргэжлийн онцлогоос хамаарч судалгаа хийх баримт цуглуулах түүнийгээ нэгтгэн дүгнэх, боловсруулах, сэргээн засах зэрэг олон арга зүйг суралцсан байна.
 - Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүнг мэргэжлийн багш нарын ажлын төлөвлөгөө, түүнийг гүйцэтгэлээс илүү харж болно. Мэргэжлийн чиглэлд зөвлөх багш оюутан тус бүртэй ажиллах боломжтой. Уран зургийн тэнхимийн бүх багш нар зөвлөн туслах үйл ажиллагааг сайн өгдөг нь оюутнуудтай хийсэн уулзалт ярилцлагаас харагдаж байсан. ДДУС-ийн оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцогч оюутнуудад зөвлөж судалгааны суурь мэдлэг өгөх боломжоор хангасан бөгөөд доктор Д.Энхдаваа, С.Бадрал нар болон бусад багш нар оролцсон байна. Оюутанд мэргэжлийн талаас зөвлөн туслах гол арга хэмжээ нь нэрт зураач уран бүтээлчидтэй уулзуулж дурсамж лекц ярилцлага хийсэн нь уран бүтээлч болох оюутнуудад маш их ач холбогдолтой юм.
 - Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалтын хувьд зөвлөх багшийн үйлчилгээний чанар хангалттай сайн байна.

- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйг төлөвшүүлэх тухайд: Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Мөнгөншагай 1-3 р курсын оюутнуудад “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн заалтыг таниулан урьдчилан сэргийлэх сургалт явуулсан байна. Дүүргийн замын цагдаагийн газраас “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” талаар, Сүрьеэтэй тэмцэх өдөрт зориулсан сургалтуудыг тус тус хийсэн байна. Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтарч “Оюуны өмч” сургалт явуулсан нь мэргэжлийн хэрэглээнд зөв чиглэл болсон байна.
- Уран бүтээлч оюутнуудын “Оюутны бүтээлч” клуб ажиллуулдаг бөгөөд спортын наадам, танилцах өдөрлөг зохиосон байна. Оюутнуудын дунд “Алтан намар” судалбар зургийн уралдаан зохиож шагналт байрт нь урамшил олгосон байна. “Хотын гудамж-миний нутаг” олон нийтийн өргөн зугаалга оюутны байгууллагаас санаачлан хийсэн байна. ДДУС-ийн амьд хөгжмийн хамтлаг тоглуулж уран бүтээлээс гадна хөгжмийн урлагаар хөгжих боломжоор хангасан байна. Ардын зураач алдартай ахмад багш нарын нэрэмжит урлангуудаар судалбар зургийн уралдаан зарлаж урамшуулан оюутнуудыг бүтээлч хандлагад чиглүүлсэн олон ажил хийсэн байна.
- Орлоготой оюутан хөтөлбөрийг ажиллуулж уран бүтээлч мэргэжлийг нь дэмжих хэлбэрээр хүүхдийн цэцэрлэгийн хананд зураг зурах, анги танхимын тохижилтонд зуучилж ажилладаг байна.
- Уран зураач мэргэжил нь өөрөө судлаач байхыг шаарддаг онцлогтой мэргэжил юм. Монгол үндэсний урлахуйн профессорын баг нь 2014 онд байгуулагдсан бөгөөд одоог болтол оюутан судлаачдыг дагалдуулан сургах, судалгаа шинжилгээ хийхэд ач холбогдол өгч ажиллаж байна. Музейгээс хэрэгтэй материалыг сонгон судлаж сурах арга зүйг дагалдуулах хэлбэрээр сургадаг байна. Хөтөлбөрт музейн дадлага тухайлан оруулсан нь сургалт болон судалгаа хийх боломжоор хангахад ач холбогдолтой байна. Дүрслэх урлагийн мэргэжлээр сурдаг магистр, доктор оюутнуудын хэмжээнд эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг, сургалт, семинар явуулсан нь ач холбогдолтой болсон байна. Түүхийн ховор нандин эд зүйлсийг сэргээн засварлах чиглэлээр оюутнуудад сургалт явуулж тэдний судалгааны ажилд хувь нэмэр оруулсан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүнг хэмжих бодлогын бичиг баримтыг их сургуулийн жишиг бичиг баримтад түшиглэн хөтөлбөрийн онцлогийг бүрэн тусгасан байдлаар боловсруулах шаардлагатай.
- Төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлэх байдал төдийлөн хангалттай бус байна.
- Монголд сүүлийн үед цөөн үлдсэн өв соёл, түүхийн эд зүйлсийг сэргээн засварлах чиглэлийн мэргэжил ховордсон байна. Сэргээн засварлагч

мэргэжлээр оюутнуудад эрдэм шинжилгээний судалгаа явуулах боломжийг илүү нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Оюутнууд урлагийн боловсрол эзэмшихээс гадна зохиогчийн эрхийн мэдлэгт тулгуурласан боловсролд суралцах нь зүйтэй. Мэргэжилтэй холбоотой зохиогчийн эрх, урлагийн бүтээлийг судалгаанд ашиглах зах зээлд судалгааны эх сурвалж болгох гадаад хүчин зүйлүүдийг давуу суралцах нь зүйтэй.

4.3. Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудын бүтээлч чиг хандлагыг хөгжүүлэх тэдгээрийн авъяас чадварыг дэмжих, нээн урамшуулах тал дээр их сургуулийн дэмжлэг, оюутны байгуулагаас ажил зохион байгуулж ажиллаж байгааг нотлох баримтаар харж болно. Өмнөх онуудтай харьцуулахад оюутны байгууллагын төсөв түүний зарцуулалт санхүүгийн баримтаар өссөн байна.
- Оюутны сайн дурын үйл ажиллагааг чиглэл бүрээр ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжиж иржээ. Тухалбал, Оюутнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах сургалт сурталчилгаанд өргөнөөр оролцуулдаг нь тайлангийн нотлох баримтанд хавсрагасан байсан. Оюутны үйл ажиллагааны төсөвт удирдлагаас тодорхой мөнгө төсөвлөдөг, 2016 онд 13,338.280 төгрөг зарцуулсан байсан. Оюутнуудын зохион байгуулсан ажлын тоо шаардлагатай мөнгөн дүнг төсөвт суулгадаг, 2013 онд 12 төрлийн ажилд 3,978.500 төгрөг зарцуулсан байна. 2017 онд оюутны дунд зохиосон ажлын тоо нь 27, нийт зарцуулсан төсөвт мөнгөн дүн нь 12,920.000 төгрөг байгаа нь 2013 онтой харьцуулахад 3,2 дахин өссөн, өмнөх оноос 3,2 хувиар буурсан байна.
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа жил бүр сургуулийн санхүүд тайлагнадаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын дунд зохион явуулж байгаа ажлын цар хүрээ, сайн дурын ажиллагаа олон байгаа ч түүнд зарцуулдаг санхүүгийн мөнгөн дүн бага, оюутнуудын мэргэжлийн онцлогт суурилсан ажилд санхүүгийн дэмжлэг хүрэлцэхгүй байх хандлага ажиглагдаж байна.
- Оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд төсөв батлан зарцуулж тайлагнадаг боловч клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийн нотлох баримтгүй, төсвийг зориулалтын дагуу зарцуулдаг байдалд хяналт тавьж ажиллах.

Зөвлөмж:

- Оюутнуудын уран бүтээлийг сургууль болон оюутны байгууллагаас дотоодоос гадна олон улсын уралдаан тэмцээнд дэмжин явуулаад чадвараа таниулах боломжоор хангах нь зүйтэй.
- Оюутны байгууллагын төсвийн зарцуулалтыг шилэн болгох боломжтой.

4.4.Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудын дунд зохион явуулж байгаа ажлыг дэмжин сургуулийн захиргаанаас тодорхой мөнгөн дэмжлэг үзүүлэн түүгээрээ хөтөлбөрийн хэрэгжилтэнд дэмжлэг болж байна.
- Урамшуулал тэтгэлэгт хамрагдаж байгаа нийт оюутны 80 хувийг уран зураг мэргэжлийн хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутнууд эзлэж байна. Тэд 50, 70,100 хувийн тэтгэлэг авч байна. Уран зураг хөтөлбөрөөр суралцаж байгаа нийт оюутнуудын тэтгэлэгт хамрагдсан байдлыг авч үзвэл Засгийн газрын тэтгэлэг, Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг, Хаан банк, Голомт банк, Зориг сан, СУИС-ийн захирлын нэрэмжит, Боловсролын зээлийн сан, буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээл гэх мэт олон төрөл байна.
- “Зураас- 2014” үзэсгэлэн (2,700,0 төгрөг зарцуулсан) танилцуулгыг хэвлүүлж олны хүртээл болгосон, Оюутны шилдэг бүтээлийн үзэсгэлэн, Хаврын гоёл гэх мэт олон уралдаанд (тус бүр шагнал урамшуулалд 500,000 төгрөг зарцуулсан) оюутнууд амжилттай оролцсон байна.
- СУИС-ийн захирлын нэрэмжит тэтгэлэг нь суралцах хугацаандаа голч дүн 3,6 ба түүнээс дээш суралцсан, уралдаан тэмцээнд онцгой ур чадвараа гаргасан тохиолдолд урамшуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдын үзүүлсэн амжилтуудыг бүртгэлжүүлэх
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэгийг ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох, бүртгэлжүүлэх

Зөвлөмж:

- Гадаадын их дээд сургууль, бусад улс орны засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, гадны сан, компанийн тэтгэлэгт хамруулах асуудлыг судлаж, урамшууллын тогтолцоог олон эх үүсвэртэй болгох боломжтой.

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг СУИС-ийн бакалаврын сургалтын журамд заасны дагуу шийдвэрлэдэг ба магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиас шилжин ирэгсэд, дотроо мэргэжил солиход кредит дүйцүүлэн тооцдог байна.
- Шилжилт хөдөлгөөний судалгаа Сургалтын албанд тогтмол хийгддэг.
- Оюутнуудын шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэх үйлчилгээ нь чирэгдэлгүй, зохион байгуулалт сайтай болох нь нотлох баримтаас харагдаж байна.

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөний судалгаа Сургалтын албанд хийгддэг боловч учир шалтгааныг тодруулах, дүгнэлт төдийлөн сайн биш. Гарч буй үр дүнг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хэрхэн тусгаж ажилладаг нь тодорхой бус.

Зөвлөмж:

- Оюутны шилжилт хөдөлгөөний шалтгааныг тодруулах, дүгнэлт хийх, үр дүнг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарч ажиллах боломжтой.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого, сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн хувьд хөтөлбөрт тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол, дадлагыг маш сайн эзэмшсэн, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий магистр зэрэгтэй 16 багштай. Багшийн сонгон шалгаруулалт нь СУИС-ийн хэмжээнд мөрдөгдөх нийтлэг журам, дүрмийн дагуу хийгддэг. Багшийн хөгжил, төлөвлөлт, хэрэгжилтэд тавих хяналтад бүрэлдэхүүн сургуулийн гүйцэтгэх үүрэг илүү байна.
- ДДУС-ийн хэмжээнд нийт 6 доктор багш байгаагаас тус хөтөлбөрт хичээл заадаг доктор багшийн эзлэх хувь бага. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь докторын зэрэгтэй багш байхгүй.
- Багш оюутны зохистой харьцаа нь 2012 онд 1:16 байсан бол 2016 онд тус харьцаа нь 1:18 болсон байна. Багш оюутны зохистой харьцааг 5 жилийн дунджаар харьцуулахад 1:16 гэсэн тоон дүн гарч байна. Тусгай мэргэжлийн чиглэлээр сурч байгаа оюутнуудын хувьд 1:16 гэсэн харьцааг зохистой харьцаа гэж болно.
- ДДУС-ийн нийт багш нарын албан тушаалын зэрэглэлийг сүүлийн таван жилээр авч үзвэл багш 7 хувь, ахлах багш 6 хувь, доктор 2 хувь, дэд профессор 1 хувь, профессор байхгүй, хүндэт профессор 3 хувь эзлэж байна. Уран зураг хөтөлбөрийн багшийн албан тушаалын зэрэглэлд дэд профессор 1, ахлах багш 3, багш 12 ажиллаж байна. СУИС-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал

доктор Н.Алтанцэцэг, эрдэмтэн нарийн бичиг доктор А. Баяртөр нарын санаачлагаар олон жил үр бүтээлтэй ажилласан, Монгол улс болон олон улсад бүтээлээрээ хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй ахмад багш нарт эрдмийн цол, зэргийг бүтээлээр нь дүйцүүлэх журам боловсруулж эрдмийн зөвлөлд танилцуулж байсан боловч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.

- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдалд СУИС-д профессор, дэд профессор цол олгох журмыг хэрэгжүүлж байгаа байдлаар дүн шинжилгээ хийж үзвэл ДДУС-ийн Уран зургийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй нэгж бараг хамаарахгүй, ялгаа их ажиглагдаж байна. Уран зургийн тэнхимд ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа 3 багшийн ажилласан жил үр дүн, ур чадвар нь профессор болон дэд профессор цолны шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан гэж үзэхээр байна. Тэнхимийн эрхлэгч дэд профессор Н.Сэргэлэн, ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа ахмад багш Г.Лхагвасүрэн, Б.Нямхүү нар нь өөрийн мэргэжлээрээ сургууль, тэнхимдээ олон жил хариуцлагатай ажиллаж хөтөлбөрийг 21-р зуунд авчирсан, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд удаа дараалан амжилт үзүүлсэн, олон арван алдартай уран бүтээлч шавь нарыг төрүүлэн гаргасан гавъяатай болох нь баримтаар нотлогдож байна.

Анхаарах асуудал:

- Уран зураг хөтөлбөрийн хүний нөөцийн дунд, урт хугацааны цогц бодлого боловсруулж ажиллах (сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилтийг хянах индикатар үзүүлэлт, түүнийг хэмжиж болохуйцаар томъёолох)
- Зэрэг, цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх
- Залуу уран бүтээлч багш нарын докторантурт суралцахад сургууль тэнхимийн зүгээс дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах (ярилцлага, тандалтаар ахисан түвшинд суралцах байдал сургуулийн бус багшийн санаачилга, хичээл зүтгэлд тулгуурлаж байна) зайлшгүй шаардлагатай байна.
- Уран зургийн тэнхимийн доктор, профессор, дэд профессор, профессор цол зэрэгтэй багшийн тоо бага байгаа нь их сургуулийн мэргэжлийн хөтөлбөрт магадлан итгэмжлэлээр тавигдах шаардлага, сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал төдийлөн сайн биш.
- СУИС гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулахдаа хөтөлбөр бүрийн онцлог, тавигдах шаардлагыг эргэж харах боловсронгуй болгох.
- Багшийн сэтгэл ханамжийн судалгааны боловсруулалтыг сайжруулах. Зураг 8.2.
- Өөрийн үнэлгээний тайланд Зураг 8.3. Оюутны үнэлгээний голч дүн нь шинэчилсэн хөтөлбөр үр өгөөжтэй байгааг илэрхийлэх эерэг үзүүлэлт гэж дүгнэсэн ч багш нартай хийсэн ярилцлага үүнийг батлахгүй байна.

Зөвлөмж:

- Тодорхой хэмжээнд Жамсран бүтээх төсөл гэх мэт багш нар багаар ажиллах, ахмад туршлагатай багш, бие биенээсээ сурах сургалт, дадлага чухал.
- Залуу багш нарыг эрдэмжүүлэх, туршлагажуулах, судалгаанд хандах эерэг хандлагыг нь бүх талаар урамшуулан дэмжих боломжтой.
- Ахмад уран бүтээлч багш нарыг мэргэжлийн ур чадварыг дүйцүүлэн профессор цолыг олгох шаардлага хангасан багш нар цөөн тооны байгаагаас тэнхимийн эрхлэгч Сэргэлэн, ахлах багш Лхагвасүрэн, Нямхүү гэх мэт багш нар байлаа.
- Олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад багш нарыг мэргэжлийн зэрэг, ур чадвараар нь буюу СУИС-ийн эрдмийн зөвлөлийн шалгуур үзүүлэлт хангасан багш нарт дэд профессор, профессор цолыг олгох боломж байна.

5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадварыг нэмэгдүүлэхэд ахмад багш нарын гүйцэтгэх үүрэг их байна. Ахмад багш нарын сурган заах арга зүйн онцлог нь тухайн хүний туршлага, ур чадварын үзүүлэлт, мэргэжил, мэдрэмжтэй шууд холбоотой байдаг ба энэ нь уран бүтээл хийх судалгааны арга зүйн түвшинг мөн илэрхийлдэг байна. Гадаадын их дээд сургуулиас уригдсан профессор багш нар, уран бүтээлчдээс суралцах хандлага өсч байгаа нь ажиглагдсан. Хөтөлбөрийн багш нар нь монгол зураг, уран зураг, монументаль уран зургаар гол төлөв мэрэгшсэн, заах арга зүйн болон судалгааны арга зүйн өөр өөрийн гэсэн ур чадвар эзэмшсэн байна. Захирлын нэрэмжит мэргэжлийн үзлэг уламжлал болсон ба энэ нь багш нар бие биенээсээ суралцах боломжийг олгодог байна. Эрдэм шинжилгээ, суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг хийж хэвшээгүй.
- СУИС-ийн хэмжээнд хэрэгжүүлэх багшийн хөгжлийн хөтөлбөртэй. СУИС-ийн багшийн хөгжлийг дэмжих бодлогод эрдэм шинжилгээ судалгаа - уран бүтээлийн

ажлыг сайжруулах гэсэн заалтууд тусгагдсан. Багшийн хөгжлийн хөтөлбөрийн үзүүлэлтийн дагуу багш нар хэрэгжилт, үр дүнгээ тодорхойлж тайлагнадаг. Уран зураг хөтөлбөрийн хувьд бүтээл туурвихтай холбоотой суурь судалгааг тасралтгүй хийж ирсэн, туршлага хуримтлуулсан байна. Хэд хэдэн улс орнуудтай хамтарсан судалгааны баг ажиллаж, амжилтанд хүрсэн байна.

- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулах ажил тодорхой хэмжээнд хийгддэг, өсөх хандлагатай. 2016 онд 10 багш урт богино хугацаанд мэргэжил дээшлүүлсэн ба өмнөх жилүүдэд энэ тоо бага байсан байна. 2016 онд 11 багш гадаадад мэргэжил дээшлүүлж сургалтанд хамрагдсан байна.
- АТЕС-ийн 2016 дэлхийн театрын боловсролын 2-р чуулган, Азийн театрын сургуулийн 4-р их наадамд амжилттай оролцсон байна. Дэлхийн олон улсын арт фестивалд уран бүтээлч зураач багш нараас уран зургийн багш О.Энхтайван АНУ-д зохиогдсон “Дэлхийн модны өдөрлөг-2017”, Итали улс, Венецийн биеннальд уран зургийн багш Ө.Гандулам, Ц.Баттөр, ОХУ-ын зураачидтай хамтарсан пленерът оролцсон багш нар цөөнгүй байгаа нь мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжиж бусад орны уран бүтээлчдээс байнга суралцдаг байна.

Анхаарах асуудал:

- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох цогц судалгааг тогтмол хийж хэвшээгүй байна.
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилтийг багш бүрийн гүйцэтгэлийн үр дүнгээр нэгтгэх замаар их сургуульд тайлагнадаг. Түүнд дүн шинжилгээ, сайжруулалт хийх асуудал төдийлөн хангалттай бус
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал урсгалаараа явагддаг.
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал
- Хувь багшийн зүгээс эрдэм шинжилгээ судалгааны нэг сэдэвт бүтээл дээр ажиллах, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлэх, хэлэлцүүлэх тал дээр дутагдалтай.

Зөвлөмж:

- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох цогц судалгааг Их сургуультай хамтран хийх боломжтой
- Багшийн хөгжлийн асуудлыг их сургууль бүрэлдэхүүн сургуулийн бусад бодлогын баримт бичигтэй уялдуулах.
- Багшийн хөгжлийн асуудалтай холбоотой багш нарын санал, санаачилга, оролцоог үйл ажиллагаандаа бодитойгоор тусгаж сайжруулалт хийж байх

5.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал
- Багш нарын эрдэм шинжилгээний хуралд хамрагдах байдал өсч байгаа хэдий ч бие даан болон хамтран хийсэн эрдэм шинжилгээний бүтээл туурвих байдалд төдийлөн ахиц гараагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн уран бүтээлийн байдлаар олон улс, дэлхийн бусад орнуудад гаргаж байгаа үзэсгэлэн уралдаануудад хамрагдах нь өндөр үзүүлэлттэй байна. Багш нар 142 бүтээл хийснээс Уран зургийн тэнхимийн багш нар нийтдээ 662 бүтээл гаргасан сайн үзүүлэлт бөгөөд инноваци шингэсэн гэж үзэх боломжтой. Эдгээрт бие даасан уран бүтээлүүд дийлэнх хувийг эзлэж байна.
- Эрдэм шинжилгээний дотоод төсөл СУИС-ийн хэмжээнд 13, үүнээс ДДУС 5 төсөл хийсэн байна. Улсын хэмжээний төсөл 6 тэдгээрийн 3 нь хамтарсан төсөл байна. Мөн Монгол-ХБНГУ -тай хамтарсан төсөл, 2016 онд Нийслэлийн 375 жилийн ойн хүрээнд “Хөгжилтэй Улаанбаатар” зургийн төсөл хийсэн бөгөөд уран бүтээлийн хүрээнд амжилттай болсон байна.
- Багш нарын судалгааны өгүүлэл нийтлэлүүд болон заадаг хичээлүүдээрээ сурах бичиг, гарын авлага, бие даасан үзэсгэлэнгээ гаргах эрдэм шинжилгээний ажил хийх хандлага өсч байна. Оюутан, багш нарын хамтарсан өв соёлын хээрийн судалгааны баг ажиллаж, түүхэн баримтат урлагийн бүтээлд судалгаа хийх зэрэг олон ажлыг уран бүтээлийн хажуугаар хамт хийж, бүтээл гаргаж байгаа нь хөтөлбөрийн сургалтын агуулгыг баяжуулах, арга зүйг боловсронгуй болгох, судалгааны шинэ шинэ чиглэлүүдийг хөгжүүлэхэд эерэг үр нөлөө үзүүлж байна.
- Уран бүтээлийн “Орон зай” танилцуулга, Монгол зургийн багш нарын бие даасан уран бүтээлийн үзэсгэлэнгийн танилцуулга, Ц.Баттөр багшийн Зууны мэдээ сонинд хэвлэгдсэн урлагийн тухай эссэ, Монголын дүрслэх урлагийн товч тайлбар тольд уран бүтээл, намтартайгаа орсон багш нар олон байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын эрдэм шинжилгээний хуралд хамрагдах байдал өсч байгаа хэдий ч бие даан болон хамтран хийсэн эрдэм шинжилгээний бүтээл туурвих байдалд төдийлөн ахиц гараагүй байна.

- Уран зураг хөтөлбөрийн хувьд бүтээл туурвихтай холбоотой суурь судалгааг тасралтгүй хийж ирсэн туршлагатай боловч судалгааны тэр их материалаа ашиглан эрдэм шинжилгээний бүтээл туурвих арга зүй, үр дүнг тооцох, шинжлэх, арга загваруудыг ашиглах мэдлэг, чадвар хангалтгүй байна.

Зөвлөмж:

- Инновацийн бүтээгдэхүүн, бүтээлд авах патентын тоог тогтвортой нэмэгдүүлэх
- Эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй эзэмших эрэлт хэрэгцээ багш нарт их байгааг харгалзан Их сургуулийн бодлого, төлөвлөлтөд багш бүрийг хамруулах, багш нарын эрдэм шинжигээний ажлыг эрчимжүүлэхэд сургуулиас дэмжлэг үзүүлэх. (арга зүйн зөвөлгөөг ScD, PhD докторуудаар өгүүлэх)

5.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын өөрийн үнэлгээний тайланд тусгасан бүтээлч хандлагууд суралцагчтайгаа ажилласан байдал зэрэг нь нотлох баримтаар сайн байна.
- Багш нарын хөндлөнгийн үнэлгээг СУИС-аас албан тушаалын зэрэглэлээр гурван жил тутамд нэг удаа 24 зүйл 3 багц асуулгаар аттестатчлал хийж үнэлж дүгнэдэг байна. Багшийн хөгжлийн төвөөс гаргасан жишиг загварын дагуу ДДУС-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн багш нарын үйл ажиллагаа жишиг загварт хэрхэн нийцэж байгааг үнэлж дүгнэдэг байна.
- Хөтөлбөр хэрэгүүлэгч нэгж, ДДУС багш бүрийн тайлан судалгааг тогтмол хэлэлцэж дүгнэн үр дүнгээр урамшуулах, алдаршуулах ажлыг хийж хэвшсэн байна.
- Багшийг оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар үнэлж дүгнэдэг байна.
- Багш бүрийн үйл ажиллагааны тайлан, баримт, материалтай нэгбүрчлэн танилцахад шаардлага бүрэн хангасан байлаа.

Анхаарах асуудал:

- Багшийн үнэлгээ бодитой, багш нар сэтгэл ханамжтай эсэхэд дүн шинжилгээ хийх.

Зөвлөмж:

- Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний шилдэг арга туршлагаудыг судлан хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх.
- Багшийн ур дүнг урамшуулах, шилдэг багш шалгаруулах зэрэгт удирдлагаас гаргасан шийдвэр хэр оновчтой, ил тод эсэхэд магадлах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход тодорхой хэмжээгээр чиглэсэн, онол практикийн зохистой харьцааг харгалзсан, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгжих боломжтой байна.

- Хөтөлбөрийн шинэчлэл хийхэд оролцогч талуудын санал хүсэлт гол үндэслэл болдог. Суралцагч болон төгсөгчдөөс авсан судалгаа, мэргэжлийн багш нарын санал, ажил олгогчид, МУЭ-ийн саналыг тусгаж ажилладаг байдал тогтмолжоогүй нь нотлох баримтаар тогтоогдсон.
- С.Ганзам багш Монгол зураг хичээлээр Е хичээл бэлтгэн, туршиж эхэлсэн нь сайн талтай.

Анхаарах асуудал:

- Цахим хичээлүүдийг Е- контент түвшинд боловсруулан сургалтад ашигладаг байдал төдийлөн сайнгүй, “Дүрсийн бүтэц” хичээлээр С.Ганзам багш хийж эхэлсэн боловч зардал, бэлтгэх цаг хугацааны хувьд хүндрэл гарсан.
- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээг тогтмолжуулах, үр дүнг хэрхэн хөтөлбөрт тусгасан талаарх нотлох баримттай болох.
- Дээд боловсролын суурь хичээлийн агуулгыг дээд боловсролын ерөнхий стандартаар бус Уран зураг хөтөлбөрийн 3 мэргэжлийн онцлогт тохируулан нийцүүлж өөрчлөх.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг анхаарсан хэдий ч уг мэргэжил нь ур чадвар суулгахад илүү анхаарах шаардлагатай байна.
- Туршлага, ур чадвараар олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй гадаадад төгссөн залуу багш нар сургалтын үйл ажиллагаанд цөөнгүй багшилж байгаа нь хөтөлбөрийн “цогц чадамжид суурилсан” байх шаардлагыг хангаж байгаад эргэлзээ төрүүлсэн.
- Сургалтын төлөвлөгөөний нэг загварт оруулсан өөрчлөлтөд оролцогч талуудын сэтгэл ханамж муу, шүүмжлэл их гарсан. Оролцогч талуудтай хийсэн уулзалт ярилцлагын үр дүнг хавсаргав.

Зөвлөмж:

- Уран зураг, Монгол зураг, Монументаль ураг зураг мэргэжлийн агуулга, хөтөлбөрийн хүрэх үр дүн, уялдаа, ялгааг нарийн тодорхойлох.
- Цахим хичээлийг Е-контент түвшинд боловсруулан сургалтад ашигладаг туршлага судлах, хэрэгжүүлэх
- Е хичээл бэлтгэх зардал, төслөөр шийдвэрлэх боломжийг СУИС-с урамшуулж дэмжих.
- Хичээл тус бүрийг зохион байгуулах хэлбэрийг дадал, ур чадвар суулгахад түлхүү чиглүүлэх
- Зохиомжийн сэдэвтэй бүтээлч сургалт, мэргэжлийн нарийвчлан задалсан өнгө дүрсийн задаргааг харуулсан мэдрэмж олгох хичээлүүдийг уламжлалт байдлаар хадгалах, алдагдуулахгүй байх.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол зургийн мэргэжлийн арга зүйг үндэсний болон Ази, дорно дахины сургалтын арга зүйд тулгуурлан боловсруулж сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.
- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан бөгөөд, суралцагч төвтэй. Хичээлийн явцад онол, дадлага хослуулан заадаг. Оюутан урланд даалгавараа гүйцэтгэх үедээ багшаас онол, зурах арга зүй эзэмшдэг. Багш дадал, чадвар олгох аргаар дүрслэх, сэтгэх арга зүйг хөгжүүлдэг юм байна. Энэ нь гараар бүтээж, сэтгэж бодох мэргэжлийн онцлогийг харгалзсан, оюутан өөрийн бүтээлч байдлаа харуулах боломж, цогц чадамжид сургахад чиглэсэн байна.
- Хяналтын багийн ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ахмад багш нарын сургалт, уран бүтээлийн арга зүйн онцлогоос судлан сургалтын арга зүйгээ баяжуулахад чиглэгдсэн “Нээлттэй урлан” үйл ажиллагаа тусгагдсан байна. (хууд.185)
- Сургалтанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи, програм хангамж, техник хэрэгсэл ашиглах чадварыг дээд боловсролын суурь заавал судлах энэ чиглэлийн хичээлээр олгодог.
- Сургалтын арга зүйн судалгааг Ази дорно дахины нэр хүнд бүхий сургууль, хөтөлбөр, профессор, уран бүтээлчдийн ур чадварыг судлах байдлаар хийж харьцуулан дүгнэх, хөгжүүлэх боломжоо эрж хайдаг.

Анхаарах асуудал:

- Мэргэжил бүрээр сургалтын арга зүйн ялгаатай байдал харагдахгүй байна. Энэ нь хөтөлбөр, мэргэжил, төлөвлөгөөний хувьд мөн адил.
- Багшийн хичээлийн файл материалаас л сургалтын арга зүйг хэрхэн боловсруулсан талаар зарим зүйлийг харахаас өөрөөр баримт бичиг, загвар нотлогдохгүй.
- ОХУ-ын Репин, Суриков, Итали, Герман, Хятадын сургуулийн арга зүйг ашиглаж байгаа боловч түүнийгээ баталгаажуулж цаасан дээр буулгасан зүйл байхгүй.

- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал гэдэгт сургалтын арга зүйг ижил мэргэжлийн гадаадын их, дээд сургууль болон академиудаас судлан “орчин үеийн дэвшилтэд техник технологийг сургалтанд нэвтрүүлэх замаар тасралтгүй шинэчлэдэг” эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, шаардлагатай программ хангамжийг сургалтанд хэрэглэдэг эсэх нь нотлогдохгүй.

Зөвлөмж:

- Багшийн урлангаар, Мастер класс (гадаад, дотоодын өндөр мэргэжлийн хүмүүс, ахлах курсынхэн, багш нар, оюутан харилцан бие биенээсээ) зэрэг арга зүйн тодорхой хэлбэрүүд байгааг баримт бичиг, жишиг загвар болгож баримтжуулах.
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, шаардлагатай программ хангамжийн судалгааг хийх, албан ёсны эрхтэй программ худалдаж авах, сургалтанд бодитой хэрэглэдэг болох.

6.3. Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сурагцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний систем, арга аргачлалтай. “Тэнхимийн үзлэг” явцын шалгалтыг хичээл эхэлснээс хойш 45 хоногийн дараа авдаг онцлогтой.
- Оюутан хичээл тус бүрээр 4 ажил гүйцэтгэсэн байх шаардлагатай бөгөөд эхний 2 ажил гүйцэтгэсний дараа явцын шалгалтыг авдаг байна. Энэ нь арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд тодорхой хэмжээнд хөтөлдөг байна.
- СУИС-ийн хэмжээнд суралцагчийн сургалтын үр дүнг ил тод, найдвартай, шударга, ижил тэгш байх зарчмаар үнэлэх систем бүрдүүлж, мөрддөг.

- Суралцагчийн гаргаж буй амжилтуудыг үнэлгээний голч дүн болон гадаад, дотоодын үзэсгэлэн, мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцсон, байр эзэлсэн байдлаар дүгнэдэг ба гаргасан амжилтууд баталгаажсан байна.

Анхаарах асуудал:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, түүний хэрэглээг хөтөлбөр, мэргэжлийн онцогт тохирч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх.
- Сургалтын хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, мэргэжлийн суурь онол, арга зүй олгодог хичээлийн кредит хангалттай бус байгаа нь уран бүтээлчийн мэдлэг, чадвар, бүтээлд хандах хандлагыг үнэлэх арга, аргачлал түүний хэрэглээг хангалттай гэж үзэхэд эргэлзээтэй.

Зөвлөмж:

- Хөтөлбөр, мэргэжлийн онцогт тохирсон, онцлогийг харгалзсан мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлалыг эргэж харах, боловсруулах, сайжруулах
- Хөтөлбөрийн өмнөх үеүдийн сургалтын зарчим гол үзүүлэлт нь суурь онолд тулгуурласан бүтээлд бодит урлагийг харуулан суралцдаг уран бүтээлчид төгсдөг байсан. Одоо суралцагч нь суурь урлагаа бүрэн судлаж амжаагүй, сургалтын явцад элдэв хэв маяг, урсгал чиглэлийг хуулбарлан дуурайх хийсвэрлэн урлах хандлагатай байгаа нь уран бүтээлчийг төөрөгдөлд оруулж болох эрсдэлтэй юм.
- Суралцагчийн үнэлгээг хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэх зорилгоор мэргэжлийн хэлцүүлэгийг ажил олгогч, ахмад уран бүтээлч, суралцагч, багш зураачдаар өргөтгөн зохион байгуулж тэдгээрийн үнэтэй зөвлөлгөөг сонсох, тусгах, харьцуулан дүгнэх боломжтой юм.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: : Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа

- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангахад чиглэгдсэн, эрэлттэй, үнэ цэнэтэй. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгаа, төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг авч эхэлсэн.
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацааг бусад мэргэжлийн адил тооцох боломжгүй. Учир нь уг хөтөлбөрөөр төгсөгч нь өөрөө өөртөө ажлын байр, урлан бэлтгэдэг, үүндээ сэтгэл ханамжтай ажилладаг, амьдрах цогц чадамжтай, чөлөөт байдлаар уран бүтээл туурвидаг, цаг хугацаанд баригдмал байдлаар чанартай бүтээл туурвих нь тэдний мэргэжлийн ёс зүйгээс зөрүүтэй байдаг зэрэг онцлог талтай холбоотой болно.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж хэвшээгүй, хөтөлбөрийн шинэчлэлд тусгах асуудал эхлэлийн байдалтай, хэрэгжилтийн үр дүнг тодорхойлоход хүндрэлтэй.
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа тогтмолжоогүй. Энэ бүлгийн судалгаа буруу хийгдсэн, тоо мэдээлэл зөрсөн, бүгд ижил үр дүн гарсан, дахин хийх (Зураг 7.4- 7.10, 7.1.3, тайлангийн хууд.161-168)
- Уран зураач мэргэжил нь сурч төгсөөд өөрийн ажлын байртай байхад их цаг хугацаа, туршлага, хөдөлмөр шаарддаг нарийн мэргэжил юм. Мэргэжлээр сурч төгссөн уран бүтээлчид уран бүтээлээ хийхийн зэрэгцээ менежер байх ур чадвар шаарддаг. Иймээс сургалтын хөтөлбөрт менежментийн хичээлүүдийг мэргэжлийн онцлогтой уялдуудлан орох хэрэгцээ байна.
- Их сургууль төр, бизнесийн байгууллагатай хамтрах замаар төгсөгчдөө ажлаар хангах, тэдний авъяас чадварыг нийгмийн захиалгад хандуулж дэмжих боломжийг эрэлхийлэх санаачлагатай манлайлж ажиллах.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол авч хэвших, хөтөлбөрийн шинэчлэлд хэрхэн тусгасан талаар тодорхой шийдвэр гаргадаг, хэрэгжилтийн үр дүнг тодорхойлох боломжтой байхаар зохион байгуулах.
- НХХЯ-ны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс гаргасан Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийг тооцох аргачилал болон төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааны арга зүйг ашиглан Төгсөгчид, ажил олгогч, сонирхогч талуудаас авах судалгаагаа боловсруулж сурах.

- Менежментийн мэргэжлийн тэнхимээс “Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа”-г авах үр дүнг боловсруулж тайлагнах тал дээр зөвөлгөө, тусламж үзүүлж байх
- Төгсөгч болон сонирхогч талууд томоохон төсөл, хөтөлбөр дээр хамтран багаар ажиллах замаар тэдний бүтээлийг зах зээлд үнэлүүлэх, ажил, орлоготой байлгах боломжтой. Энэ ажлыг СУИС, ДДУС санаачлан зохион байгуулж хэрэгжүүлж болно. Энэ нь бие биенээсээ суралцах, хөгжих, хамтарч ажиллах, эргэх холбоотой байх, чанартай, үнэ цэнэтэй бүтээл гарах, сургууль, хөтөлбөрийн нэр хүндийг өргөх, зорилго, зорилттой нягт уялдах ач холбогдолтой.
- Гадаадын улс оронд уран бүтээлчдээ дэмжин хотын болон нийгмийн хэрэгцээт урлаг шаардсан газруудыг төрийн бодлогоор дэмжиж хөгжүүлдэг туршлага байна.

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр нь 72 үр дүнгээ үнэлүүлсэн, үнэ цэнэ нь тодорхой, ахиц дэвшлээ харуулах хангалттай нотлох баримттай, урлагийн салбар болон хөдөлмөрийн зах зээл дээр тэргүүлэх байр суурьтай, Монгол улсад монгол зураг, уран зураг, монументаль урлагийг хөгжүүлэхэд олон улсын тавцанд үнэлэгдэхэд хөтөлбөрөөр төгсөгчид өөрсдийн бүтээлээрээ үнэтэй хувь нэмэр оруулсаар байна.

•

Анхаарах асуудал:

- МУБИС, ШУТИС, Урлах эрдэм ДС, Завханы коллеж, Их засаг, МҮИС, Сити ИС зэрэг ижил төрлийн сургалт явуулдаг өрсөлдөгчид тасралтгүй бий болж байгаад дүгнэлт хийх.
- НХХЯ-ны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс хийсэн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2017, Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (2010-2011 оны төгсөгчид)- 2016 он (2015-2016 оны төгсөгчид) -2017 оны судалгааны үр дүнг харах тайланд оруулах.

Зөвлөмж:

- Шинээр бий болсон хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлдэг их дээд сургуулийн амжилт, онцлог, давуу талыг судлах, Уран зураг хөтөлбөрөөр лаборатори гол

сургууль гэдгээ дотоод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар удирдлагын бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх

- Хөтөлбөрийн онцлог, давуу талаа хадгалж, хамгаалах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үндэсний хэмжээнд суралцагчдын цогц чадамжийг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэхийн тулд анх удаа хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж байгаа. Өмнө нь байгууллагын магадлан итгэмжлэлд орсон. Олон улсын магадлан итгэмжлэлд ирээдүйд орох зорилт тавьж ажиллаж байгаа. Төгсөгчид болон багш нараа олон улсад ахисан түвшинд суралцах боломжийг тодорхой хэмжээнд дэмжин ажилладаг. Магистрын сургалтаар цөөн тооны гадаад оюутан сургадаг, энэ тоо өсөх боломжтой. Улсын болон олон улсын чанартай мэргэжлийн үзэсгэлэн, уралдаанд багш, оюутнууд байнга оролцож тодорхой амжилт үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Бакалаврт суралцдаг гадаад оюутангүй.
- Хөрш улсуудын мэргэжлийн их дээд сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх дунд, урт хугацааны бодлого боловсруулах.
- Улсын болон олон улсын чанартай мэргэжлийн олимпиадад оролцох байдал хангалтгүй/ байхгүй, үзэсгэлэн, уралдаанаар хязгаарлагдаж байна.
- Суралцагч, төгсөгчдийн цогц чадамжийг хөгжүүлэхэд анхаарах.
- 6 докторант багштай. Тэдний докторын сургалт, зэрэг хамгаалах ажлын явцын графикийг хянах, дэмжиж ажиллах шаардлагатай.

Зөвлөмж:

- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн магистр, докторын хөтөлбөрт багш, төгсөгчдийг үргэлжлүүлэн суралцуулах асуудлыг СУИС-ийн хөгжлийн бодлого,

санхүүгийн болон хүний нөөцийн төлөвлөлтөд тусгах, дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлж ажиллах.

- Уран зургийн хөтөлбөрөөр улсын чанартай мэргэжлийн олимпиад зохион явуулах боломжтой. Агуулга нь онол, бүтээл, сэтгэлгээ, шууд чадвар тодорхойлох зэргээр байж болох талтай. (Бүрэн дунд боловсрол/их дээд сургуульд суралцагчид/сонирхогчдын дунд байж болох юм.) Авъяаслаг, шагналт байранд орсон оролцогчдыг урилгаар сургах гэх мэт.
- Бакалавр, магистрт суралцах гадаад оюутны тоог нэмэгдүүлэх, олон улсын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар тогтмол давтамжтай үнэлгээ хийлгэж хэвших,
- Улсын болон олон улсын чанартай мэргэжлийн олимпиад, уралдаан, тэмцээнд оролцох байдлыг тасралтгүй дэмжих. Энэ нь хөтөлбөрийн хүрсэн түвшинг олон улс, дотоодод хэрэглэгчдээр үнэлүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Төгсөгчдийн цогц чадамжийг нэмэгдүүлэх богино хугацааны модуль сургалтыг Төгсөгчдийн холбоо, ТББ-тай хамтран явуулдаг болох.

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар “Амгалан орчлон”, Соёлын наадам, “Бид сайн сайхан дагуулна” иргэдийн баяр, “Орон зай” нийгэмлэгээс зохион байгуулдаг үзэсгэлэн, олон улсын “Нордорм” дүрслэх урлагийн үзэсгэлэн, симпозиум, Монгол Солонгосын дүрслэх урлагийн өдөрлөг, үзэсгэлэн, “Соёл ба хөгжил” соёлын чуулган, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”, “Хөгжилтэй улаанбаатар”, Боловсролын үзэсгэлэн яармаг, Элсэлтийн хөтөч 2018-2019 танилцуулах материал, Оюутны клуб, хамтлагт зөвлөх багш нар, 12 жилийн сургуульд багш бүр хийдэг мэргэжил сурталчлах үйл ажиллагаа зэрэг олон арга хэмжээ зохион байгуулж, оролцон олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг. Олон улс болон дотоодод зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, тэмцээний мэдээлэл, шагнал урамшууллын талаарх зарим мэдээллийг СУИС, ДДУС-ын вебсайтаар

тодорхой хэмжээнд, харин хөтөлбөрийн фэйс группээр хөтөлбөр, мэргэжлийн үйл ажиллагааны зар, үр дүнг нилээд дэлгэрэгүй мэдээлж сурталчилгааг хангалттай хийдэг.

Анхаарах асуудал:

- 7.4-ийн тайлагнал хангалтгүй бичигдсэн боловч шинжээчийн баг ажиллах явцад нотлох баримт хангалттай байсан.
- Вэб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа хангалтгүй. СУИС, ДДУС албан ёсны хуудсаар мэдээлэл сурталчилдаг хэдий ч мэдээлэл иж бүрэн биш, шинэчлэл хийгдэ нь удаан.

Зөвлөмж:

- Вэб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол шинэчлэл хийж ажиллах.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2016-12-16-ны хурлаар Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлж, 3 үе шаттай хэрэгжүүлэх шийдвэр гаргасан. Чанарын

баталгаажуулалтын зохион байгуулалтын схем боловсруулсан. Одоогоор чанарын шалгуур үзүүлэлтийг тогтоох, дүрэм журам боловсруулах ажлууд хийгдэж байгаа.

- Тэнхимийн зүгээс сар болгон багш нарын хичээлийн явцад хяналт тавьж багш нарын хурлаар үр дүнг хэлэлцэн цаашид хийх ажлыг төлөвлөн гүйцэтгэж байдаг. Тэнхим нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дотоод чанарын үнэлгээ хийх хяналтыг багш, төгсөгчдийн төлөөллөөс бүрдсэн багаар үе шаттай хийлгэж ирсэн. Захиргааны төлөөлөл бүх багш нар ордог, 8 чиг үүрэгтэй.
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын нэгж нь сургуулийн захиргаа, профессорын баг, хэрэгжүүлэгч тэнхим байна. Нэгж нь хөтөлбөрийн хэрэгжилтийг явцад явцын үнэлгээ, хэлэлцүүлэг, үзэсгэлэн, нээлттэй хичээл, сэтгэл ханамжийн судалгаа зэрэг үйл ажиллагаагаар хянаж дүгнэдэг.
- СУИС 2017-2018 оны хичээлийн жилийг “Сургалтын чанарын баталгаажилтын жил” болгон зарласан үр дүн гарах болоогүй байна. 2014 оноос хойш хөтөлбөрт 2 удаа шинэчлэл хийсэн, үр дүн нь сургалтын нэг циклээр хэмжигдэнэ.
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг онол, дадлагын зохистой харьцаа бүрдсэн, оюутны үнэлгээний голч дүн, мэргэжлийн уралдаан тэмцээнд орсон амжилт, явцын болон улирлын шалгалт, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтээр хянадаг.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх зохилгоор төгсөгчдийг мөшгих судалгааг эхлүүлсэн.

Анхаарах асуудал:

- СУИС-с хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтыг томъёолсон, хэрэгжүүлэх шийдвэр гаргасан ч үр дүнг тодорхойлох шийдэлд хүрээгүй, удаашралтай.
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, түүний дагуу хийсэн төлөвлөгөө, хэрэгжилтийг үнэлэх тодорхой арга зүй байхгүй.
- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудад чиглэсэн үйл ажиллагаа хангалттай явуулдаг ч дотоод чанарын баталгаажуулалт, түүний төлөвлөлтөд тэдний ямар санал, зөвлөгөөг хэрхэн тусгасан эсэх, оролцоо нь баримтаар нотлогдохгүй, зөвхөн төгсөгч багш нараар хязгаарлагдаж байна.
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдээр онол, дадлагын зохистой харьцаа бүрдсэн, оюутны үнэлгээний голч дүн дээшилсэн үр дүн гарсан ч ажил олгоч, төгсөгч, сонирхогч талуудтай хийсэн ярилцлагаар энэ өөрчлөлтийн үр нөлөөг эерэгээр хүлээн авахгүй байгааг эргэж хянаж үзэх.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн эргэх холбоо өргөн хүрээнд биш, төгсөгчдийг мөшгих судалгааг авч хэвшээгүй.

Зөвлөмж:

- СУИС хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод чанарын баталгаажуултын механизмыг бий болгох, хэрэгжүүлэх ажлыг шуурхайлах, мэргэжлийн удирдлагаар хангах.

- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрт өөрчлөлт оруулахдаа багш, ажил олгогч, төгсөгч, сонирхогч талуудын санал зөвөлгөөг авч тусгах (энэ нь зах зээлийн эрэлтэд нийцэхэд чиглэгдэнэ), гадаад зах зээл, олон улсын чиг хандлагыг баримжаалах, 2014 оноос хойш хийсэн өөрчлөлтийн үр нөлөөг дахин хянаж үзэх.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн эргэх холбоог нэмэгдүүлэх, төгсөгчдийг мөшгих судалгааг байнга авч хэвшүүлэх.

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Дүгнэлт:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл		+		Сургалтын стандарт орчин сайн бүрдээгүй
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.	+			
5	Багшийн үйл ажиллагаа	+			
6	Сургалтын үйл ажиллагаа	+			
7	Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	+			
8	Чанарын үнэлгээ, баталгаажилт		+		Дотоод чанарын баталгаажуулалт эхлэж байгаа
Дүгнэлт		“Уран зураг” хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдэх боломжтой.			

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг СУИС-ийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн “Уран зураг” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Б.Энхтуяа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг/Б.Төмөрбаатар/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../М.Моломжамц/

Хавсралт 1

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

№	Багшийн нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Мэргэлийн чиглэл	Заадаг хичээл
1	Н.Сэргэлэн	УЗТ-ийн эрхлэгч	Дэд проф Магистр	14	Монгол зураг	Бүтээлч уран сэтгэлгээ, Монгол зургийн зохиомжийн онцлог
2	Г.Лхагвасүрэн	Ахлах багш	Докторант	33	Уран зураг	Чөлөөт зохиомж, Нүцгэн натур дүрс, Нүцгэн натур өнгө
3	Б.Нямхүү	Ахлах багш	Докторант	25	Монгол зураг	Дүрсийн бүтэц, Дүрсийн харьцаа, Материал судлал, Галбир зүй
4	Ө.Гандулам	Ахлах багш	Докторант	17	Уран зураг	Чөлөөт зохиомж, Нүцгэн натур дүрс, Нүцгэн натур өнгө, Өнгийн бүтэц, Өнгийн хоршил
5	О.Энхтайван	Багш	магистр	22	Уран зураг	Өнгийн бүтэц, Өнгийн хоршил, Дүрсийн бүтэц, Дүрсийн харьцаа, Өнгийн алслалт, Материал судлал
6	Г.Амарсанаа	Багш	Докторант	19	Монгол зураг	Өнгийн бүтэц, Өнгийн хоршил, Материал судлал
7	С.Ганболд	Багш	магистр	36	Уран зураг	Өнгийн бүтэц, Өнгийн хоршил, Дүрсийн бүтэц, Дүрсийн харьцаа, Материал судлал
8	С.Ганзам	Багш	магистр	20	Монгол зураг	Танза зургийн бэлэгдлийн дүрслэл, Танка зургийн урлах ур ухаан, Монгол зургийн зохиомжийн онцлог, Байгалийн дүрст зохиомж, Амьтан дүрст зохиомж
9	Г.Амгаланбаатар	Багш	магистр	13	Монументаль уран зураг	Чөлөөт зохиомж, Нүцгэн натур дүрс, Нүцгэн натур өнгө,

10	Ц.Баттөр	Багш	магистр	12	Уран зураг	Өнгийн материаллаг шинж чанар, Дүрсийн материаллаг шинж чанар, Хүн дүрст зохиомж, Сэдэвт зохиомж, Хөрөг өнгө, Хүн дүрслэл дүрс
11	М.Чинбат	Багш	магистр	13	Монгол зураг	Нүүдэлчдийн дүрслэх ур ухаан, Монгол зургийн хэллэг, Хүн дүрст зохиомж, Сэдэвт зохиомж
12	Ж.Дархижав	Багш	магистр	2	Уран зураг	Хуулбар/байгал, Хуулбар/хөрөг, Өнгийн алслалт, Өнгийн гэрэл сүүдэр, Байгалийн дүрст зохиомж, Амьтан дүрст зохиомж
13	Д.Баатарсүрэн	Гэрээт багш	магистр	2	Уран зураг	Гобелен, Сграфито, Өнгийн бүтэц, Хүн дүрст зохиомж, Сэдэвт зохиомж
14	Б.Алтантовч	Гэрээт багш	магистр	1	Уран зураг	Энкаустика, Батика, Сонгодог хуулбар, Чөлөөт хуулбар, Дүрсийн хэлбэр, Дүрсийн гэрэл сүүдэр

II. Оюутны нэр

№	Оюутны овог, нэр	Мэргэжил	Курс	Сонгосон байдал
1	Э.Нямдэлгэр	Монгол зураг	4	Онц сурлагатан
2	Д.Энхбаяр	Уран зураг	4	Оюутны зөвлөлийн гишүүн байсан
3	Э.Хүслэн	Монументаль уран зураг	2	СУИС-ийн Бадмаараг ахлах сургууль төгсөж ДДУС-д элссэн
4	Ш.Ерсин	Монументаль уран зураг	4	Төгсөх курсын оюутан
5	О.Цэцэн	Монументаль уран зураг	3	Хөгжлийн бэрхшээлтэй
6	Э.Энхжин	Монументаль уран зураг	3	Онц сурлагатан
7	М.Энхцацрал	Монументаль уран зураг	4	Онц сурлагатан
8	Н.Лүндээцжанцан	Уран зураг	3	Онц сурлагатан
9	Б.Билгүүн	Монгол зураг	1	ДДУС-ийн зохион байгуулдаг "Амгалан Орчлон" гар зургийн уралдаан тэргүүн байр эзэлж сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй элссэн оюутан

* **Сонгосон байдал** Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг, курс бүрээс, оюутны холбооны гэх мэт

III. Ажил олгогч

№	Төлөөлөл	Байгууллага	Албан тушаал
1	Б.Сарангоо	Монголын урчуудын эвлэл	Ерөнхий менежэр
2	Намуун	Дүрслэх урлагийн музей	Мэргэжилтэн
3	Ш.Тамир	Монгол зургийн нийгэмлэг	УЗ-ийн гишүүн
4	Г.Ганбаатар	Арилдал ХХК /хэвлэлийн газар/	Захирал
5	Дамдинсүрэн	UB art галлерей	Захирал
6	С.Зэсээ	Залуу уран бүтээлчдийн нэгдэл	Тэргүүн
7	Жавзмаагийн оронд П.Дэлгэржаргал	Үлэг гүрвэлийн музей	ХНМ

IV. Төгсөгчид

№	Төгсөгчдийн нэрс	Төгссөн он	Мэргэжил	Байгууллага	Албан тушаал
1	Б.Батцэцэг	2017	Монгол зураг	СУИС	Магистр
2	Сэр-Од		Уран зураг	МУЭ-ийн Арт галерей	Галерейн зохион байгуулагч
3	Б.Содномдаржаа	2009	Уран зураг	Лувсанвандан Арт галерей	Бодь группийн зураач
4	Д.Өлзийтогтох	2012	Монгол зураг	МУЭ	Гишүүн зураач
5	Д.Эрдэнэчулуун	2013	Монгол зураг	МУЭ	Гишүүн зураач
6	Э.Түвшинтөр	2011	Монгол зураг	МУЭ	Гишүүн зураач
7	Б.Будбаяр	2010	Монутенталь	СУИС	Магистр
8	А.Мөнгөнцоож	2008	Монгол зураг	Соёлын Өвийн Төв	Сэргээн засварлагч
9	Ш.Тамир	2007	Монгол зураг	Монгол зургийн нийгэмлэг	УЗ-ийн гишүүн
10	А.Нямдорж	2012	Монгол зураг	Бие даасан уран бүтээлч	Зураач
11	Б.Сарангоо	2002	ЧУЗураг	Монголын урчуудын эвлэл	Ерөнхий менежэр
12	С.Цацрал	2012	Монгол зураг	Бие даасан уран бүтээлч	Зураач

Хавсралт 2

**Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн “Уран зураг” сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь
2018 оны 5 дугаар сарын 1, 2**

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2018-05- 01	Мягмар гараг	
09:00-10:00	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна	Зохицуулагч
	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ: - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	Шинжээчийн багийн ахлагч
	Сургуулийн захирал үг хэлнэ	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Удирдлага болон ӨҮ-гийн багтай уулзах: - Удирдлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	Шинжээчийн багийн ахлагч
10:00-12:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана	Шинжээчид
12:00-13:00	Сургуультай танилцах аялал	Шинжээчид
13:00-14:00	Өдрийн хоол	
14:00-16:00	Оюутнуудтай хийх уулзалт	Шинжээчид
	Багш нартай хийх уулзалт	Шинжээчид
16:00-17:00	Шинжээчид номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана	Шинжээчид
17:00-18:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	Шинжээчид
2018-05-02	Лхагва гараг	
09:00-10:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	Шинжээчид
10:15-11:15	Төгсөгчидтэй хийх уулзалт	
11:30-12:30	Ажил олгогчидтой хийх уулзалт	
12:30-13:30	Өдрийн хоол	
13:30-14:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
14:30-17:00	Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/	
17:00-18:00	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	



СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
ДҮРСЛЭХ, ДИЗАЙН УРЛАГИЙН
СУРГУУЛЬ

14181 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
11 дүгээр хороо, СУИС-ийн хичээлийн II байр,
Утас: (976) 7013 7059

Д.Н.В. 15 № 02/2022
танай _____-ны № _____-г

БМИҮЗ-Д

Тус сургуулийн “Уран зураг-021301” бакалаврын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмлэх шинжээчдийн багийн тайланг уншиж танилцан сургуулийн захиргааны зөвлөлийн хурал, тэнхимийн хуралаар хэлэлцэн шинжээчийн дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байгаагаа хүргүүлж байна.

Шинжээчийн тайлангийн зарим зөвлөмж, дүгнэлтэнд сургуулийн зүгээс тайлбар хийсэн бөгөөд хавсралтаар хавсаргав.

СУРГАЛТЫН АЛБАНЫ

ДАРГА  Ж.АЗЗАЯА